

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ДОТООД ХЯНАЛТ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАЙЛАН

Оршил

Байгууллагтай холбоотой гаргасан хууль тогтоомж, Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, аудитын дүгнэлтийн хэрэгжилтийн биелэлт, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын нэгдсэн үзлэг тооллогын хийх болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан.

Хяналт шинжилгээ үнэлгээний зорилго

Монгол улсын хууль, Монгол Улсын Их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, Аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрийн хэрэгжилт, Засаг даргын Тамгын газрын тушаал, шийдвэрийн хэрэгжилтэндийн үр дүнд эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж мэдэгдэл хүргүүлэх.

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгосон 2021 оны тендерийн баримт бичгийг төрийн аудитын газарт хүргүүлэн, аудитын дүгнэлтийн төсөлд болон дүгнэлтэд тайлбар тодрууллага тухай бүрт хүргүүлэн ажилласан. Манай байгууллагын санхүүгийн тайланд томилолтын зардал нөхөн төлүүлэх акт тавигдсан байсан бөгөөд холбогдох албан хаагчдаас төлүүлсэн байна.

Байгууллагын эд хөрөнгөд хагас бүтэн жил тутам тооллог хийж эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгсөн.

Бүрэнтогтох суманд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалган зааварчлах ажлын удирдамж гарган тухайн суманд газрын дарга болон худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэнтэй хамтран ажиллаж холбогдох байгууллагуудын үнэлгээний хороонд ажилладаг ажилтан албан хаагчдад сургалт зөвлөгөө өгч ажилласан.


Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын нэгдсэн үзлэг тооллогын хийх болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсэг гарган бүх сумдад байгууллагын албан хаагчид ажиллаж тухай бүрт нь гарсан хяналт шалгалт хийж зөвлөгөө зааварчиллагаа өгч ажилласан.

2022 онд батлагдсан зураг төсөвгүй төсөл арга хэмжээний жагсаалтыг гаргаж, албаны дарга хөрөнгө оруулалтын хэлтэс болон аймгийн Засаг дарга, Тамгын газрын дарга нарт албан бичгээр хүргүүлсэн.

Манай байгууллага нь шилэн дансны мэдээлэлийг цаг тухай бүрт нь нягтлан бодогч оруулж ажилласан байна. E-Balance, Нийгмийн даатгалын тайлан, татварын тайланг цаг тухай бүрт тайлагнан ажилласан байна. Жилийн эцсээр Хяналт-шинжигээ үнэлгээний тайланг гаргаж, өгсөн зөвлөмжийн биелэлтийг хүргүүлэн ажилласан. Өмч хөрөнгөтэй холбоотой тогтоол шийдвэрийг цаг тухай бүрт нь гаргуулан ажилласан. Актласан болон хөрөнгө нэмэгдсэн эсэхэд хяналт тавьж ажилласан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын нэгдсэн үзлэг тооллогын гарсан зөрчил дутагдалыг хоблогдох байгууллагуудад нь хүргүүлэн залруулах арга хэмжээ авч ажилласан байна. Актлах хөрөнгийн дуудлага худалдааг хууль журмын дагуу зохион байгуулан тайлагнасан байна. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хяналт суларсан төлөвлөгөөний төсөлөө хянуулдаггүй, явуулж буй үйл ажиллагааны тайлангаа ирүүлдэггүй гээд өмчит аж ахуй нэгжүүд манай байгууллагын хяналтаас гарсан харагдаж байна. Өмч хөрөнгийн түрээсийн гэрээний биелэлт хэрэгжилт хангалттай сайн биш байна. Мөн Сангийн яамнаас 2021 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний хүрэн 37 төсөвт байгууллагууд болон орон нутгийн өмчийн оролцоотой компаний тайлан төлөвлөгөө болон цахим сисемийн хэрэгжилтийн талаар үнлэгээ хийж холбогдох арга хэмжээг авхаар аймгийн засаг даргад хүргүүлэн ажилласан нь энэ оны онцлох ажил болсон.

Цаашид анхаарах зүйлс:

1. Тендерийн баримт бичгийн цаг тухай бүрт нь албаны даргаар хянуулж зарлаж байх.
2. Батлагдаагүй зураг төсөв, ажлын даалгавараар тендер зарлахгүй байх
3. Дотоод хяналтын ажилтанд архивийн баримтаа шалгуулж хүлээлгэн өгөх, цахим архив үүсгүүлэх
4. Санхүүгийн үр ашигтай зарцуулалтын талаар албан хаагчид танилцуулж байх
5. Орон нутгийн өмчит компаниудыг цаашид хэрхэн харилцах талаар арга хэмжээ зохион байгуулах

ТАЙЛАН ГАРГАСАН: ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖИЛТЭН,
ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН  Д.ТӨМӨР

ХЯНАСАН: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ДОЛЖИНСОРОГДОГ

